



СОЁЛЫН ЯАМ



**СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

“Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх журам”-ын 2 дугаар хавсралт

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Үзүүлэлтүүд	Төсөв /мян. төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хэрэгжилт болон тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилт							
1	Зорилт 1.1 Засгийн газрын тогтоолоор баталсан үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах						
1.1.1	Засгийн газрын 2019 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах	3,126.6	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв-Лимбэний битүү амьсгааг хамгаалах төслийн 1, 2 дугаар үе шатыг хэрэгжүүлсэн	- ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв-Лимбэний битүү амьсгааг хамгаалах төслийн 3 дугаар үе шат хэрэгжсэн байна. - ЮНЕСКО-гийн II зэрэглэлийн хүрээлэн ICHCAP-тай (БНСУ) Монгол Улсын 120 Соёлын биет бус өвийн мэдээллийг Олон улсын	Энэхүү зорилтын хүрээнд 3 төрлийн арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэсэн. 1. “Лимбэний битүү амьсгааны уламжлал” баримтат киноны дүрс бичлэг, эвлүүлэг, “Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис” CD-ний эх бэлтгэл, Лимбэчдийн намтар танилцуулга бүхий номын эхийг тус тус бэлтгэж бүрэн дуусгасан. Үр дүнд хөтөлбөрийн 3 дугаар шатны бэлтгэл ажил хангагдав. ЮНЕСКО-гоос Төрийн банкны гадаад төлбөр тооцооны дансанд нэр, дансны дугаарын мэдээлэл зөрүүтэй шилжүүлсэн шалтгаанаар төслийн санхүүжилт буцаагдсан тул бүрэн хэрэгжээгүй. 2. ICHLINKS төслийн хүрээнд: 2.1. Монголын соёлын биет бус өвийг Олон улсад сурталчлах зорилгоор 4 аймгийн 7 суманд соёлын биет бус өвийн дүрс цуглуулах, баримтжуулах, 90 өвийн тодорхойлолт, гэрэл зураг бэлтгэх, 3 хүртэлх минутын 30 контентийг бүтээсэн.	96%

					<p>онлайн мэдээллийн санд байршуулан сурталчлах ichLinks төслийг хэрэгжүүлсэн байна.</p> <p>- “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн 2021 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтран оролцоно.</p>	<p>2.2. “Хэрлэнгийн барьяа” уртын дууны анхдугаар наадмыг Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутагт орших “Сэрвэн хаалга” хэмээх дурсгалт газрыг түшиглэн амжилттай зохион байгуулав. Уг наадамд зүүн бүсийн 4 аймгийн 18 сумаас 20 өвлөн уламжлагч оролцож, Монгол ардын уртын дууны өвийг сурталчлан, түгээн дэлгэрүүлэв.</p> <p>Төслийн үр дүнд Ази, Номхон далайн улс орнуудын ichlinks.com олон улсын мэдээллийн санд Монгол Улсын соёлын биет бус өвийн 120 өвийн мэдээллийг байршуулж, дэлхий нийтэд сурталчлах боломж нээгдсэн.</p> <p>3. “Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-ын дагуу 21 аймаг, нийслэлээс нэр дэвшүүлсэн өвлөн уламжлагчийн баримт, хэрэглэгдэхүүн, материалыг нэгтгэн Соёлын яаманд хүргүүлсэн.</p> <p>Шилдэг өвлөн уламжлагчийг тодруулах ажлын бэлтгэл хангагдлаа.</p>	
1.1.2	Засгийн газрын 2019 оны 69 дугаар тогтоолоор баталсан “Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах	1,898.3	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Хөтөлбөрийн хүрээнд 2019 оноос хойш 10 арга хэмжээг зохион байгуулсан.	<p>- Баруун болон зүүн бүсийн чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p>- 3 томоохон цогцолбор дурсгалын оршин буй газрыг кадастрын улсын бүртгэлд</p>	<p>1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан чулуун дурсгалын бүртгэн баримтжуулах, томоохон цогцолбор дурсгалын оршин буй газрыг кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх, чулуун дурсгалд анхан шатны цэвэрлэгээ, сэргээн засварлалт хийх ажлын удирдамж, төсвийг боловсруулж удирдах дээд байгууллагад хүргүүлсэн.</p> <p>Төсөв санхүүжилт олгогдоогүйн улмаас хэрэгжээгүй болно.</p> <p>2. Хөтөлбөрийн 2.4.2-д тусгагдсан Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших Хэсэг байшинтын гэрэлт хөшөөний чулуун мэлхийг зөөж тээвэрлэх ажлыг 2021 оны 12 дугаар сард хийж гүйцэтгэв. Устас</p>	75%

					<p>бүртгүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.</p> <p>- Устах эрсдэлд орсон 1 чулуун дурсгалыг аюулгүй газар зөөж байршуулсан байна.</p> <p>- 1 чулуун дурсгалд анхан шатны цэвэрлэгээ, сэргээн засварлалтыг хийсэн байна.</p>	<p>эрсдэлд орсон дурсгалыг аюулгүй газарт шилжүүлэн байршуулснаар хадгалалтын нөхцөл сайжирч, авран хамгаалагдав.</p>	
1.1.3	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 77 дугаар захирамж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/176 дугаар тушаалаар баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах</p>	3,548.4	<p>Соёлын өвийн RCH мэдээллийн санд бүртгэсэн бичиг, соёлын дурсгалын тоо</p>	<p>Шинээр хэрэгжүүлж эхэлнэ.</p>	<p>“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III” - ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.15 дугаар заалт 40 % хэрэгжсэн байна.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн музей, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг 33 байгууллагын бүртгэл, мэдээллийн санд “Монгол бичиг, соёлын дурсгалт зүйл”-д хамаарах 1126 дэсийн 1800 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл бүртгэлтэй байна. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн “RCH” программд:</p> <ul style="list-style-type: none"> - 609 дэсийн 1115 ширхэг үзмэр буюу 54,08 % нь бүртгэгдсэн; - 517 дэсийн 685 ширхэг буюу 45,91% нь бүртгэлгүй байна. <p>Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээлийн сан (цаашид СӨУНБМСан гэх)-д бүртгэлтэй байгууллагуудаас Монголын Үндэсний музей, Төрийн түүхийн музей, Хөшөө Цайдам музей, Дорноговь аймгийн музей, МУИС-ийн Археологийн Антрополгийн тэнхим зэрэг 5 байгууллагаас мэдээгээ ирүүлээгүй, ШУТИС–ийн Хүмүүнлэгийн сургуулийн археологийн олдворын сан хөмрөгт монгол</p>	100%

						бичиг соёлын дурсгалд хамаарах эд өлгийн зүйл байхгүй болохыг мэдэгдсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтээр анх удаа Монгол бичиг соёлд хамаарах үзмэр эд өлгийн зүйлийн төрөлжсөн цахим сан үүсгэх боломж, үр дүн гарч байна.	
1.2	Зорилт 1.2 Салбарын стратеги төлөвлөгөөнд туссан ажлын төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах						
1.2.1	Соёлын сайдын 2021 оны 02 сарын 08-ны өдөр баталсан Стратеги төлөвлөгөөний Зорилт 1-ийн хүрээнд холбогдох журмын төслийг шинэчлэн боловсруулахад хамтран ажиллах	5,736.8	Арга хэмжээний хэрэгжилт, тоо	Шинэчлэн болон шинээр боловсруулна а.	- 3-аас доошгүй холбогдох журмын төсөлд санал өгч, хамтран ажилласан байна. - Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтын ерөнхий зарчим боловсруулсан байна.	Нийт 2 журам, 1 дүрэм, 1 аргачлал, 2 стандарт боловсруулах ажлын хэсэгт хамтран ажилласан, 1 ерөнхий зарчмыг боловсруулсан. Үүнд: 1. Соёлын яамны Соёлын өвийн газартай хамтран: 1.1 “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг таньж тогтоох, бүртгэх журам”, 1.2 “Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журам”, 1.3 “Музейн сан хөмрөгт үзмэр оруулах, гаргах хөдөлгөөний дүрэм”, 1.4 “Музейн үнэлгээ хийх аргачлал, үнэлгээ хийх этгээдэд тавих шалгуур”, 1.5 “Музейн барилга байгууламжийн стандарт”, 1.6 “Музейн сан хөмрөгийн аюулгүй байдалд тавигдах шаардлага стандарт”-ын төсөл. 2. Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтын ерөнхий зарчим боловсруулан, Соёлын яаманд хүргүүлсэн. Эдгээр баримт бичиг боловсруулагдсанаар соёлын өвийн эрхзүйн зохицуулалт сайжрах чухал алхам болсон.	100%
1.2.2	Соёлын сайдын 2021 оны 02 сарын 08-ны өдөр баталсан Стратеги төлөвлөгөөний Зорилт 2-ийн хүрээнд “Цахим соёлын өв”	2,320.1	Архитектур төлөвлөлтийн даалгаврын хэрэгжилт	Шинээр хэрэгжүүлж эхэлнэ.	Соёлын өвийн 3-н төрлөөр төлөвлөлтийн даалгавар гүйцэтгэсэн байна.	Соёлын сайдын 2020 оны А/70 тоот тушаалаар тус яамны Соёлын өвийн газар, Үндэсний төв, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Математик, тоон технологийн хүрээлэн, Үндэсний дата төв, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газруудын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг	100%

	сангийн системийн архитектур төлөвлөлтийн даалгаврын урьдчилсан санал боловсруулах					байгуулагдаж, соёлын өвийн цахим мэдээллийн санг хөгжүүлэх урьдчилсан ажлын даалгаврыг боловсрууллаа. Энэхүү ажлын даалгавар нь: <ol style="list-style-type: none"> 1. Хэрэгцээ, шаардлага 2. Системийн ерөнхий бүтэц 3. Системийн архитектурын ерөнхий шаардлага 4. Функциональ ба функциональ бус шаардлага 5. Ажлын даалгаврыг нарийвчлан боловсруулах арга зам 6. Системийн хөгжүүлэлт хийх гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага 7. Хавсралт хэсгээс бүрдэнэ. <p>Ажлын даалгаврын урьдчилсан санал нь соёлын өвийн цахим санг төрийн холбогдох бусад цахим сангуудтай уялдуулах, цахим үзэсгэлэн, сурталчилгааны талбар бий болгох, шинжлэх ухааны эргэлтэнд оруулах зэрэг нэн шаардлагатай асуудлыг системийн түвшинд шийдвэрлэхэд түлхэц өгөх чухал ач холбогдолтой баримт бичиг болох юм.</p>	
1.2.3	Соёлын сайдын 2021 оны 02 сарын 08-ны өдөр баталсан Стратеги төлөвлөгөөний Зорилт 3-ийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн барилгыг ашиглалтад оруулж, тохижуулах	2,983.0	Ашиглалтад орж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн байдал	Барилгын үйл явц 98 хувийн гүйцэтгэлтэй, нүүлгэн шилжүүлэх ажлын гүйцэтгэл 70 хувь	Барилгыг ашиглалтад оруулж, төвийн үйл ажиллагааг 100 хувь жигдрүүлсэн байна.	Ашиглалтад орсон шинэ байрандаа нүүх ажиллагааг 2021 оны 01 сараас эхэлсэн үе шаттай зохион байгуулан 05 дугаар сард бүрэн дуусгаж, үйл ажиллагаа жигдэрсэн. 2021 оны 12 дугаар сарын байдлаар барилгын: <ul style="list-style-type: none"> - Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас байр эзэмших гэрчилгээ гараагүй. - Барилгын цахилгаан шат; - Мини театр /80 хүний суудалтай/ тус тус ашиглалтад ороогүй байна. <p>Монголын Урлагийн Зөвлөл, “РИО ТИНТО” ХХК-ийн дэмжлэг, хөрөнгө оруулалтаар тус Мини театрын дотоод</p>	100%

						тохижилтын ажлыг хийж эхлүүлээд байна. Шинэ байр ашиглалтад орсноор ажлын байрны орчин нөхцөл эрс сайжирч, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг бүс нутаг, олон улсын түвшинд гүйцэтгэх боломж бүрдэж байна.	
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд							
2	Зорилт 2.1 Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг төгөлдөржүүлэх						
2.1.1	Соёлын өвийн тоон дүнг нэгтгэх (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.2 дахь заалт)	1,842.45	Хамрах хүрээ, нэгтгэгдсэн соёлын өвийн тоо	Жил бүр шинэ тоон дүн нэгтгэгдэнэ.	2020 оны улсын хэмжээн дэх: -Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, -Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, -Соёлын биет бус өв, өвлөн уламжлагч тус бүрийн нэмэлт, шилжилт хөдөлгөөний тоог шинээр нэгтгэсэн байна.	1. СӨУНБМСангаас 2021 оны I улиралд 2020 оны соёлын өвийн тоон дүнгийн мэдээ нэгтгэх ажлыг зохион байгуулав. Тоон дүнгийн нэгтгэлээр: - 9754 дурсгалт газрын 90043 түүх, соёлын үл хөдлөх дурсгал, - 140940 дэсийн 336449 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, - соёлын биет бус өвийн 7 ай савд хамаарах 10849 өвлөн уламжлагч байна. Улсын хэмжээнд соёлын өвийн тоон дүнг нэгтгэн боловсруулснаар соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах чиглэлээр оновчтой бодлого шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой.	100%
2.1.2	Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2 дахь заалт)	1,842.45	Мэдээллийн санг баяжуулсан цаасан болон цахим хэрэглэгдэхүүн ий тоон дүн	Жил бүр шинэ тоон дүн нэгтгэгдэнэ.	21 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл, 10 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, 30 соёлын биет бус өв, Нийт 60 хүртэлх соёлын өвийг дүрс бичлэг, цахим контентоор баримтжуулсан байна.	1. “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэлтэй Төрийн ордон, Монголын Үндэсний номын санд хадгалагдаж буй 21 дурсгалт зүйлийн 1787 кадр (5.6 GB) гэрэл зураг, 74 GB дүрс бичлэгээр баримтжуулсан. Ажлын дүнд хосгүй үнэт дурсгалт зүйлийн дүрс бичлэгийн баримтжуулалт 2,7 хувиар нэмэгдэж, нийт 778 хосгүй үнэтийн баримтжуулалтыг 90 хувьд хүргэв. 2. Соёлын биет бус өвийн 18 төрөл зүйлд хамаарах 16 өвлөн уламжлагчийн 252.14 GB хэмжээтэй гэрэл зураг, дүрс бичлэг цуглуулж, биет бус өвийн 30 контентийг бүтээсэн.	100%

						<p>3. Хувийн өмчийн 5 иргэний 12 ширхэг эд өлгийн зүйл (байгалийн өвийн 1ш, шашин шүтлэгийн холбогдолтой 11ш)-ийг бүртгэв.</p> <p>4. 2020 онд хийгдсэн археологи, палеонтологийн хайгуул, малтлага судалгааны 7 байгууллагын 104 (археологийн 96, палеонтологийн 8) тайланг хүлээн авсан.</p> <p>СӨУНБМСан түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл, үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийн нийт 326.14 GB (гэрэл зураг, дүрс бичлэг) цахим мэдээллээр баяжигдав.</p>	
2.1.3	<p>Соёлын өвийн бүртгэлийн программд нэмэлт хөгжүүлэлт хийх</p> <p>(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8 дахь заалт, Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм)</p>	3,548.4	<p>1.Түүх, соёлыг хөдлөх дурсгалт зүйлийн “RCH” “Register” программд нэмэлт хөгжүүлэлт хийсэн байдал</p> <p>2. Соёлын биет бус өвийн www.ich.mongoluv.mn программ хөгжүүлэлт хийсэн байдал, СББӨ-ийн мэдээллийг шилжүүлсэн тоо</p>	<p>1. Түүх, соёлыг хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн программд нэмэлт талбар анх удаа шинээр үүсгэж, хөгжүүлэлт хийнэ.</p> <p>2. Соёлын биет бус өв, Өвлөн уламжлагчийн бүртгэлийн программ анх удаа боловсруулагдсан.</p>	<p>1.“RCH” программд хувь хүний бүртгэл, “дутсан”, “солигдсон”, “актлагдсан” үзмэрийн талбар бий болгосон байна.</p> <p>“Register” программд хасаж актлагдсан үзмэрийн мэдээллийн талбарыг бий болгосон байна.</p> <p>2.www.ich.mongoluv.mn цахим бүртгэлийн программд 10495 соёлын биет бус өвийг өвлөн</p>	<p>1. “RCH” программд хувийн өмчийн соёлын өвийг бүртгэх, төрийн болон орон нутгийн өмчийн музейн “дутсан”, “солигдсон”, “актлагдсан” үзмэрийн талбар нэмэх, “Register” программд хасаж актлагдсан үзмэрийн талбарыг тус тус нэмэх бодлогын даалгаврыг боловсруулсан. Төсөв хүрэлцээгүйн улмаас программуудад талбар нэмэх хөгжүүлэлт хийгдэж чадаагүй.</p> <p>2. Соёлын биет бус өвийн бүртгэлийн www.ich.mongoluv.mn программд:</p> <ul style="list-style-type: none"> - 7 ай савд хамаарах 362 соёлын биет бус өвийн товч тодорхойлолтыг шилжүүлж дууссан. - 21 аймаг, 9 дүүргээс анхан шатны байдлаар бүртгэгдсэн 10849 өвлөн уламжлагчаас 7738-ыг программд шилжүүлсэн. Үүнээс 3311 өвлөн уламжлагчийн регистерийн дугаар давхардсан, нас, хүйс, өвийн төрөл зүйл, ажил эрхлэлтийн мэдээлэл зөрүүтэй мэдээллийг нягтлан шалгаж засах ажиллагаа хийгдэж байна. <p>Уг программ ашиглалтад орсноор соёлын биет бус өвийн мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран түргэн шуурхай солилцох, улсын хэмжээнд дүн мэдээг</p>	75%

					уламжлагч, 362 өвийн тодорхойлолт мэдээллийг программд шилжүүлсэн байна	нэгтгэн боловсруулахад ахиц дэвшил гарсан.	
2.2	Зорилт 2.2 Соёлын өвийн үзлэг, тооллого зохион байгуулахад хамтран оролцох						
2.2.1	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллого зохион байгуулахад оролцох (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дахь заалт)	5,446.7	Дурсгалын тоо, хийсэн ажлын чанар	2015 онд зохион байгуулсан. 2020 онд удирдамжийг боловсруулсан.	Мэргэжил, арга зүйгээр хангаж арга хэмжээг хамтран зохион байгуулсан байна.	Өмнөх онд боловсруулсан тооллогын удирдамжийг шинэчилж, үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөө, төсвийн саналыг боловсруулж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүлсэн.	100%
2.2.2	Соёлын биет бус өвийн үзлэг зохион байгуулахад оролцох (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дахь заалт)	5,446.7	Үзлэгийн бэлтгэл ажил, зохион байгуулахад оролцсон үйл ажиллагааны тоо	2018 онд зохион байгуулахад оролцсон. 2020 онд удирдамжийг боловсруулсан.	Мэргэжил, арга зүйгээр хангаж арга хэмжээг хамтран зохион байгуулсан байна. Аймаг, орон нутгийн бүртгэлийн программын сайжруулалт хийгдэж, хэвийн ажиллагааг хангасан байна.	Соёлын биет бус өвийн улсын үзлэг зохион байгуулахад шаардагдах программ хангамжийн нэмэлт хөгжүүлэлтийн бодлогын даалгавар, төсөв, удирдамжийг шинэчлэн боловсруулж, Соёлын яаманд хүргүүлсэн.	100%
2.2.3	Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдэд хадгалагдаж буй бурхан шүтээн, эд	3,548.4	Төлөвлөгөөт ажлын чанар, тоон дүн	2020 онд МБШТ Гандантэгчэнлин хийдэд хадгалагдаж буй бурхан	-Тоон дүнг нэгтгэсэн байна. - Цахим программд	2020-2021 онд хийгдсэн Гандантэгчэнлин хийдийн улсын тооллогоор: · Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамаарах 8333 дэсийн 46070 ширхэгийг тоолж, "GandanData" программд бүртгэн, "Тоолов" тэмдгээр баталгаажуулсан.	100%

	<p>өлгийн зүйлийн улсын тооллогыг тайлагнах</p> <p>(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дахь заалт)</p>			<p>шүтээн, эд өлгийн зүйлийн улсын тооллогыг зохион байгуулсан.</p>	<p>шилжсэн байна.</p> <p>- Соёлын яаманд танилцуулсан байна.</p>	<p>- Тоологдсон бурхан шүтээн, эд өлгийн зүйлийг нэг бүрчлэн гэрэл зургаар баримтжуулж 9248 фолдер бүхий 26944 кадр (181GB) гэрэл зургийн цахим сан бүрдүүлсэн.</p> <p>· “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн 15 дэсийн 15 ширхэг хосгүй үнэт бурхан шүтээнийг баримтжуулж 292 мин 57 сек-ийн дүрс бичлэг хийсэн.</p> <p>Тооллогын тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүлсэн.</p> <p>Тооллогын үр дүнд хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн цахим бүртгэл сайжирч, дараагийн ээлжит тооллогыг түргэн шуурхай, үр дүнтэй явуулах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.</p>	
2.3	<p>Зорилт 2.3 Соёлын биет өвийг сэргээн засварлах</p>						
2.3.1	<p>Соёлын биет өвийн хүрээлэн буй орчны болон материалын судалгаа (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47.1 дахь заалт)</p>	2,610.1	<p>Судалгааны ажлын тоо, чанар</p>	<p>2020 онд 2 удаагийн материалын судалгаа, 1 удаагийн хүрээлэн буй орчны судалгаа хийгдсэн.</p>	<p>Дүрслэх урлагийн музей, Уран зургийн галерей, Богд хааны ордон музей, орон нутгийн 2 музей, нийт 5 байгууллагад хүрээлэн буй орчны судалгаа хийгдсэн байна. Материалын төрөлжсөн судалгаа 1 удаа хийгдсэн байна.</p>	<p>Хүрээлэн буй орчны судалгааг 5 байгууллагад хийсэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дүрслэх урлагийн музейн үзмэрийн хоргоны органик хүчлийн хэмжилт хийх харьцуулсан судалгаа, 2. Монголын уран зургийн галерей, Богд хааны ордон музей, Хархорум музейд тус тус өнгө будгийн гандалтын судалгаа болон чийгшил үүсэх 3 төрлийн параметр үзүүлэлтийг тодорхойлох судалгаа, 3. Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаанд бүртгэлтэй чулуун дурсгалуудад чулуулгийн гандалтын судалгааг тус тус хийсэн. <p>Судалгааны үр дүнд соёлын биет өвийн хүрээлэн буй орчны эрсдэлийн шалтгааныг тодорхойлох, тогтвортой орчин бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх суурь судалгааны аргазүйг боловсруулсан.</p>	100%

						<p>Материалын орц найрлага тодорхойлох судалгаа:</p> <p>- Үндэсний төв архив, Монголын үндэсний музей, Чингис хаан, Хархорум, Ховд аймгийн музейн 152 үзмэрт, - 13 хөшөө чулуун дурсгалд.</p> <p>Өнгө будгийн элементийн найрлагыг тогтоох судалгаа:</p> <p>- Богд хааны ордон музей, Төвхөн хийд, Шанхын Баруун хүрээ хийд, Эрдэнэ Зуу музейн барилгад тус тус хийсэн.</p> <p>Судалгааны үр дүнд соёлын биет өвийн материал, өнгө будгийн орц найрлагыг таньж тогтоох, сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын тогтвортой орчин бүрдүүлэх мэдээллийн сан 323 цэгийн хэмжилтийн мэдээллээр баяжигдсан.</p>	
2.3.2	<p>Нийтийн өмчийн түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах</p> <p>(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 46.6 дахь заалт)</p>	2,610.1	Сэргээн засварласан дурсгалын тоо	2020 онд 19 байгууллагын 49 үзмэр, эд өлгийн зүйлийг сэргээн засварласан, 1 музейн 3 үзмэрт хуулбар хийсэн.	Нийт 11 байгууллагын 31 ширхэг үзмэр сэргээн засварлагдсан байна. Үүнд: металл 6ш, даавуу 9ш, уран зураг 6ш, мод 4ш, уран баримал 3ш, арьс 3ш.	<p>Нийтийн өмчийн 10 байгууллагын нийт 33 ширхэг үзмэрийг сэргээн засварласан.</p> <ol style="list-style-type: none"> 1. Уран зургийн галерей 2ш, 2. Сүхбаатар аймгийн музей 3ш, 3. Дорнод аймгийн музей 4ш, 4. Завхан аймгийн музей 5ш, 5. Баян-Өлгий аймгийн музей 3ш, 6. Орхон аймгийн музей 2ш, 7. Дорноговь аймгийн музей 1ш, 8. Хөвсгөл аймгийн музей 1ш, 9. Монголын Үндэсний музей 1ш, 10. Гандантэгчэнлин хийдийн 11ш үзмэр болно. <p>Эдгээрээс уран зураг 5ш, арьсан эдлэл 4ш, мод 2ш, металл 5ш, яс 1ш байна.</p> <p>Төлөвлөгөөнд тусгагдсан Хэнтий, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн музей “Ковид-19” цар тахлын байдлаас шалтгаалж 10 ширхэг үзмэрээ ирүүлээгүй, 2022 онд сэргээн засварлуулахаар хойшлуулсан байна.</p>	100%

						Монголын үндэсний музей, Гандантэгчинлэн хийдийн хүсэлтээр 12 үзмэр сэргээн засварласан. Үзмэрүүдэд сэргээн засварлалт хийгдсэнээр насжилтыг уртасгах, музейн үзүүлэлт дэглэх болон олон нийтэд сурталчлах боломж нөхцөлийг бүрдүүлэв.	
2.3.3	Археологийн малтлага судалгаанаас илэрсэн олдвор, эд өлгийн зүйлийг бэхжүүлэх (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47.1 дахь заалт)	610.1	Бэхжүүлэлт, анхан шатны цэвэрлэгээ хийсэн олдвор, эд өлгийн зүйлсийн тоо	2020 онд 184 археологийн малтлага судалгаанаас илэрсэн олдворт цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийсэн.	2021 онд археологийн хээрийн малтлага судалгаанаас илэрсэн олдворуудад хадгалалт хамгаалалт, цэвэрлэгээ, бэхжүүлэлт, сэргээн засварлалт хийсэн байна.	Археологийн малтлага судалгаанаас илэрсэн 179 ширхэг олдворт хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтыг олон улсын стандартын дагуу хийсэн. Үүнд: 1. Чингис хаан музей, ШУТИС-ын хамтарсан судалгаагаар Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Их Оорцог дурсгалт газраас илрүүлсэн 65ш олдвор, 2. Археологийн хүрээлэнгийн судалгаагаар Увс аймгийн Зүүнговь сумын нутаг дахь Бүрдний элс гэх газрын булшнаас илрүүлсэн 1ш олдвор, 3. Монгол-Германы хамтарсан судалгаагаар илрүүлсэн 16ш модон эдлэл, 4. Монголын үндэсний музейн судалгаагаар илрүүлсэн 99 ширхэг олдвор, 5. Ховд их сургууль, аймгийн музейн хамтарсан судалгаагаар илрүүлсэн 9 олдвор. Археологийн олдворуудыг цаг алдалгүй хадгалан хамгаалж, сэргээн засварласнаар насжилтыг уртасгах, судалгааны эргэлтэд оруулах, олон нийтэд сурталчлах боломж бүрдсэн.	100%
2.4	Зорилт 2.4 Соёлын өвийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах						
2.4.1	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах.	3,126.6	Арга хэмжээний хэрэгжилт	Анх удаа	Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх	1. Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах 15 аймаг, 4 судалгааны байгууллагаас ирүүлсэн саналыг нэгтгэж Соёлын яаманд хүргүүлэв.	100%

	(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3 дахь заалт)				дурсгалын жагсаалтад нэмж оруулах дурсгалын санал нэгтгэгдэнэ. Үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүс тогтоох аргачлал батлагдсан байна. Аймаг, нийслэлийн хамгаалалтын жагсаалт дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, ашиглалтын судалгаа дүгнэлт гарсан байна.	1. Засгийн газрын 2021 оны 179 дүгээр тогтоолоор улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад 16 дурсгал нэмсэнээс 6 дурсгалыг шинээр бүртгэж, 10 дурсгалын зэрэглэлийг ахиулсан байна. Түүнчлэн 4 дурсгалын сум болон газрын нэрийг залруулсан. Нэмэлт, өөрчлөлтөөр улсын хамгаалалтад байх дурсгалын тоо 197 боллоо. 2. Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын үнэлгээ хийх судалгааны маягт, хөтлөх зааврын хамт боловсруулав. Үнэлгээ хийх ажлыг үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллоготой уялдуулан хийхээр төлөвлөж байна. 3. Үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүс тогтоох аргачлалын төслийг Хот төлөвлөлт судалгааны институттэй хамтран боловсруулсан.	
2.4.2	Дэлхийн өвийн жагсаалтад соёлын өвийг бүртгүүлэх ажилд хамтран оролцох (Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.7 дахь заалт)	3,126.6	Арга хэмжээний хэрэгжилт	“Буган чулуун хөшөө, хүрлийн үеийн цогцолбор” өвийг Дэлхийн өвд бүртгүүлэхтэй холбогдох нэмэлт засварыг бэлтгэсэн.	Дэлхийн өвийн жагсаалтад “Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор” өвийг бүртгүүлэх, “Наурыз” баярыг ЮНЕСКО-ийн төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлэх урьдчилсан	1. “Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор” дурсгалыг Дурсгалт газрыг соёлын өвийн ангиллаар Дэлхийн өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх ажлын хэсэгтэй хамтран баримт бичгийг Дэлхийн өвийн төвд хүргүүлсэн хэдий ч нэмэлт асуумж, сайжруулан боловсруулах зөвлөмж ирсний дагуу үргэлжлүүлэн ажиллаж байгаа. 2. Наурызын баярыг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлэх урьдчилсан судалгааны ажлыг зохион байгуулах ажлын бэлтгэлийг хангах хүрээнд Соёлын өвийн улсын нэгдсэн	80%

					судалгааны ажлыг зохион байгуулахад хамтран ажилласан байна.	бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн “Наурыз” өвийг өвлөн уламжлагчдын бүртгэлийг гаргасан. Улсын хэмжээнд Наурыз өвийг өвлөн уламжлагч 4 хүн байна. “Наурыз” өвийг нэр дэвшүүлэхтэй холбогдуулан 2021 оны 08 дугаар сард Соёлын яамны Соёлын өвийн газар, Соёлын өвийн үндэсний төв болон Баян-Өлгий аймгийн музейн төлөөлөл Улаанбаатар хотноо уулзалт хийсэн. “Наурызын баяр” өвийг нэр дэвшүүлэхтэй холбогдох судалгааны ажлыг ажлын даалгавар боловсруулагдсаны дараа дахин хэлэлцэхээр тохиролцсон.	
2.4.3	ЮНЕСКО-ийн СББӨ, Дэлхийн өвийн тайланг хүргүүлэх, хамгаалахад хамтран ажиллах (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3 дахь заалт)	1,898.3	Хүргүүлсэн тайлангийн тоо	Анх удаа	Дэлхийн өвийн жагсаалтад соёлын өвийн ангиллаар бүртгүүлсэн 3 газар, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн 5, нийт 8 тайлан илгээгдсэн байна.	1. Дэлхийн өвийн жагсаалтад соёлын өвийн ангиллаар бүртгүүлсэн "Орхоны хөндийн соёлын дурсгалт газар", "Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор", "Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг"-ийн хугацаат тайланг ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс хамгаалалтын захиргаадтай хамтран боловсруулж, хүргүүлэв. 2. Яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсаалтад бүртгэгдсэн “Монгол тууль”, “Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг”, “Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг”, “Монгол уран бичлэг”, “Уул овоо тахих Монгол зан үйл” зэрэг өвүүдийн хугацаат тайланг боловсруулж хүргүүлэв. Дэлхийн өвийн газруудын хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүд нэгдсэн байдлаар тайлангийн ажилд оролцон хоорондоо туршлага солилцсон нь тэдний мэдлэг ойлголт, чадавхийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн. 2010 оноос хойш Монгол Улсаас Дэлхийн өвд бүртгүүлсэн газруудын хадгалалт	100%

						хамгаалалтын нөхцөл байдал, менежментийн үйл ажиллагааны явцыг мониторинг хийхэд тус тайлан нь чухал ач холбогдолтой болсон бөгөөд Монгол Улсын тайланг 2022 онд Дэлхийн өвийн хорооны хурлаар авч хэлэлцэн холбогдох зөвлөмж, шаардлагуудыг ирүүлнэ.	
2.4.4	Шүүхийн шийдвэрээр хураагдсан соёлын биет өвийг холбогдох байгууллагад шилжүүлэх ажлыг зохион байгуулахад хамтран оролцох (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3, 52.8 даг заалт)	4,211.5	Арга хэмжээний хэрэгжилт	2 аймгийн музейд 119 ширхэг хураагдсан соёлын биет өвийг шилжүүлсэн.	Холбогдох хууль, журмын дагуу соёлын биет өв мэргэжлийн байгууллагад хадгалагдаж, бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдэж, хамгаалагдана.	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021/ШЦТ/19 тоот шийтгэх тогтоолын дагуу эрүүгийн 1903013090009 тоот хэргийн дугаар бүхий “412 ширхэг түүх, соёлын дурсгалт зүйлс болох судар, бурхан, шашны холбогдолтой эд зүйлс, 2 ердийн судар”-ыг Өмнөговь аймгийн музейн сан хөмрөгт шилжүүлж, бүртгэл, мэдээллийн санд бүртгэх арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээг хэрэгжүүлснээр соёлын өв эрх зүйн хувьд хамгаалалтад орж, хадгалалт хамгаалалтын нөхцөл сайжирч, музейн сан хөмрөг шашны холбогдолтой эд өлгийн зүйлээр баяжигдсан.	100%
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд							
3	Зорилт 3. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах						
3.1	Сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөө зэрэг хүний нөөцтэй холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх /Хөтөлбөр, төлөвлөгөөг хавсаргав/	2,983.0	Сургалтын тоо, хамрагдсан мэргэжилтний тоо, агуулгын чанар	2020 онд албан хаагчдад чиглэсэн дотоодын 4, гадаадын 2 сургалт нийт 6 сургалт зохион байгуулагдсан.	- Азийн өндөр хөгжил бүхий 2-оос доошгүй улстай (БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн г.м) хамтарсан “Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт”-ын чиглэлээр цахим	- Цахим сургалтын тухай тайлангийн 4.3-т тусгагдсан. - Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагч; - Худалдан авах ажиллагааны анхан шатны “АЗ” сургалтад 4 албан хаагч тус тус тэнцэж мэргэжлийн гэрчилгээ авсан. - Соёлын яам, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, Төрийн албаны зөвлөл, Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтуудад давтагдсан тоогоор 15 албан хаагч хамрагдсан.	100%

					сургалтад мэргэжилтнүүдийг хамруулсан байна. - Архив, албан хэрэг хөтлөлт, Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан байна.	Ажилтнууд сургалтад хамрагдсанаар мэдлэг, чадавхи нэмэгдэж ажлын бүтээмж дээшилсэн.	
3.2	Хууль тогтоомж, нийтээр мөрдөх эрх зүйн акт, нийтлэг хүлээх үүргийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх	2,983.0	Хяналт шалгалт хийсэн тоо	2020 онд 4 удаа дотоод хяналт шалгалт хийсэн.	Өмнөх шалгалтын үр дүн, шалгалтын мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	- Өмнөх шалгалтын мөрөөр байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын цахим файл сангийн дутуу бүрдлийг хангуулж PDF хэлбэрээр 2021 оны 12-р сарын байдлаар 1.6GB хэмжээтэй 46 хавтас бүхий 961 файл хадгаламжийн нэгж үүсгэсэн. - Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал тутамд хяналт шалгалт хийж, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгч гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангав. - Үндэсний төвийн захирлын 2021 оны А/07, А/09, А/12, А/13 дугаар тушаалаар Захиргааны зөвлөл, Өмч хамгаалах зөвлөл, Баримт бичиг нягтлан шалгах комисс, Хяналт шалгалт, дотоод аудитын нэгж тус тус зөвлөлүүдийн бүрэлдэхүүн, журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
Дөрөв.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
4	Зорилт 4.1 Соёлын өвийн чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэх, соёлын өвийг сурталчлах						

4.1	<p>Соёлын өвийн лавлагаа, мэдээлэл олгох</p> <p>(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 24.1 дэх заалт)</p>	11,039.9	Лавлагаа мэдээлэл өгсөн тоо	2020 онд 26 иргэн, 60 орчим байгууллагад хүрч үйлчилсэн.	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу соёлын өвийн чиглэлээр лавлагаа мэдээллийг тухай бүр өгч, төрийн үйлчилгээг хүргэсэн байна.	<p>СӨУНБМСангаас 5 байгууллага, 3 иргэний хүсэлтээр давхардсан тоогоор 20 удаа соёлын өвийн лавлагаа, мэдээлэл өгч үйлчилгээ үзүүлэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Чингис хаан музейн хүсэлтээр үзмэр, эд өлгийн зүйлийн мэдээлэл, Уран зургийн галерейн хүсэлтээр 106 үзмэр давхар бүртгэлтэй эсэх лавлагаа, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол улсын их сургууль, Сангийн яамны хүсэлтээр холбогдох лавлагаа мэдээлэл, - Иргэн Б.Баатархүүгийн хүсэлтээр соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн, - Ж.Мяндасын хүсэлтээр 21 аймгийн 2256 гар урчуудын, - Н.Мягмарсүрэнгийн хүсэлтээр 2018-2019 оны түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн тайлан зэрэг лавлагаа, мэдээллийг тус тус хүргүүлсэн. 	100%
4.2	<p>Соёлын биет өвийг таньж тогтоох үйлчилгээ үзүүлэх</p> <p>(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.7 дахь заалт)</p>	3,838.5	Таньж тогтоосон соёлын өвийн тоо	2020 онд 7 удаа аж ахуй нэгж, иргэний хүсэлтээр 183 ширхэг эд, зүйлийг таньж тогтоох үйлчилгээ үзүүлсэн.	Хууль, хяналтын байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтээр үйлчилгээ үзүүлсэн байна.	<p>Соёлын биет өвийг таньж тогтоох үйлчилгээг 12 иргэнд үзүүлж, 76 ширхэг эд өлгийн зүйлд анхан шатны шинжилгээ хийж, тодорхойлолт гаргав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хоёр иргэний 7 ширхэг эд зүйл түүх, соёлын дурсгалт зүйлд хамрагдахыг, 10 иргэний 69 эд өлгийн зүйл түүх, соёлын дурсгалт зүйлд хамрагдахгүй болохыг тус тус тодорхойлж дүгнэлт гарган, хүргүүлсэн. <p>Шинжээчийн дүгнэлт гаргуулах албан хүсэлт ирүүлсэн 4 (Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба, Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газар, Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар, Монголын үндэсний музей) байгууллагаас 7 удаа ирүүлсэн 27 эд өлгийн зүйлд дүгнэлт гарган хүргүүлсэн. Үүнд:</p>	100%

						<p>- Шинжилгээнд хамрагдсан эд өлгийн зүйлээс 8 ширхэг нь түүх, соёлын дурсгалт зүйлд хамрагдахыг, 19 нь түүх, соёлын дурсгалт зүйлд хамрагдахгүй болохыг тодорхойлов.</p> <p>Хүсэлт ирүүлсэн 12 иргэн, 4 байгууллагын 103 ширхэг эд өлгийн зүйлийг тодорхойлон дүгнэлт гаргаж төрийн үйлчилгээг үзүүлсэн.</p>	
4.3	<p>Сургалт зохион байгуулах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх</p> <p>(Салбарын стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх зорилт3-ийн хүрээнд болон Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм)</p>	11,039.9	Зохион байгуулсан сургалтын тоо	2020 онд 8 удаагийн сургалт, 17 удаагийн мэргэжил, арга зүйн зөвлөмж өгсөн.	<p>“Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалт”-5 удаа, “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэх нь” сэдвээр 5 удаа, Нийт 10-аас доошгүй цуврал сургалтыг зохион байгуулна.</p>	<p>Хадгалалт хамгаалалтын чиглэлээр Япон, Итали, БНСУ-ын мэргэжлийн байгууллагатай хамтран 8 сургалт, Үндэсний төвөөс бие даан 11 сургалт тус тус зохион байгуулсан.</p> <p>Зохион байгуулагдсан нийт 19 сургалтад (танхим, цахим хосолсон 9, цахимаар 10) улс, аймгийн музей, Үндэсний номын сан, Архивын ерөнхий газар, Эрдэм шинжилгээний хүрээлэн, Их дээд сургууль зэрэг 44 байгууллагын давхардсан тоогоор 553 хүн хамрагдсан.</p> <p>Дээрх сургалтуудаар музейн хүрээлэн буй орчны судалгааны олон улсын арга зүй болон соёлын биет өвийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын чиглэлээр мэдлэг олгосон.</p> <p>“Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэх нь” сэдвийн хүрээнд улс, аймаг орон нутаг, нийслэлийн музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг 44 байгууллагын давхардсан тоогоор 300 гаруй ажилтнуудыг хамруулсан нийт 7 удаагийн сургалт зохион байгуулсан. Үүнд: “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 4, “Музейн үзмэрийн Register болон RCH бүртгэл программын ашиглалт болон бүртгэлийн бүрдүүлэлт” сэдэвт цахим сургалт 3 удаа зохион байгуулсан.</p>	100%

						Соёлын өвийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх мэргэжил, арга зүйгээр хангаснаар соёлын өвийн шат шатны бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, ашиглалт зэрэг олон талт үйл ажиллагаанд ахиц дэвшил гарах ач холбогдолтой.	
4.4	Соёлын өвийг хамгаалах, сурталчилах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ зохион байгуулах (Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 24.2, 49.2.3, 50.1 дэх заалт)	11,039.9	Зохион байгуулсан арга хэмжээ, контент, нэвтрүүлэг, гарын авлага, сэтгүүлийн тоо	2020 онд Уулзалт, арга хэмжээ-4, Телевизийн нэвтрүүлэг, ярилцлага-4 Эрхэлж гаргасан ном, хэвлэл-7	Соёлын өвийн мэдээ мэдээлэл бүхий 1 цахим сэтгүүл, соёлын өвийг хамгаалах аргазүйн 2 гарын авлага, 5-оос доошгүй телевизийн нэвтрүүлэг, 3-аас доошгүй видео шторк хийгдсэн байна.	Цахим сэтгүүлийн 1 дугаар, 2 гарын авлага, радио, телевизийн 7 нэвтрүүлэг, 4 дүрс бичлэг шторк бэлтгэх, түгээх арга хэмжээг зохион байгуулсан. -“Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүлийн 9 дэх дугаар; -“Даавуу болон арьсан эдлэлийн хадгалалт хамгаалалт хийх арга зүй” гарын авлага; -“Түүх соёлын үл хөдлөх дурсгалын байршил тогтоох, GPS ашиглах, хэмжилт хийх, DRONE-ний хэрэглээ” гарын авлага; -“Монгол орны үзэсгэлэнт байгаль түүхэн, дурсгалт газрууд төсөл”-ийн хүрээнд “Титанс пикчерс” ХХК-тай хамтран баримтат цуврал нэвтрүүлэг, -“Mongol HD” телевизийн мэдээллийн хөтөлбөрт 2 удаа байгууллагын үйл ажиллагааг тус тус олон нийтэд сурталчлав. -“Монголын үндэсний хүүхдийн кино академи”-тай хамтран соёлын өвийг сурталчилсан “Хори” кинонд зөвлөхөөр, “Цэц” өв соёл, танин мэдэхүйн 13 цуврал нэвтрүүлэг, -МҮОНТ-тэй хамтран “Монголын өв соёлын гайхамшиг” 7 цуврал нэвтрүүлэг, -МҮОНТ-тэй хамтран “Мөнх сайхан төрт Алтан Торц баатар” туулийн цуврал нэвтрүүлэг, -МҮОНР-ийн “Соёлын цаг” шууд нэвтрүүлгээр Соёлын бүтээлч сарын	100%

						<p>аяны зорилго, хийгдэж буй ажлуудын талаарх ярилцлага, -Соёлын яам, Үндэсний төвийн цахим хуудсаар дамжуулан “Цахим орчинд соёл түгээе, Би хариуцлагатай иргэн” аяны хүрээнд соёлын өвийн мэдээллийг, “Цагаан суварга”, “Монгол номадик”, “Дэл уулын чулуун судар” тусгай үзэсгэлэн болон байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 4 арга хэмжээний дүрс бичлэг, шторкийг тус тус бэлтгэж түгээсэн. Соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах танин мэдүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ач холбогдолтой болсон.</p>	
5	Тав. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн нэмэлт болон он дамжин хэрэгжиж буй ажлын хэрэгжилт						
5.1	Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах	3,838.5	Зөвлөл хуралдаж шийдвэр гаргасан тоо	2021 онд 1 удаа хуралдаж зөвлөмж, дүгнэлт гаргасан.	Соёлын өвийн үндэсний төвийн дэргэдэх орон тооны бус зөвлөлөөр Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийгдсэн байна.	<p>Үндэсний төвийн дэргэдэх тус зөвлөл нь архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх чиг үүргийн хүрээнд дараах 2 удаагийн арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p> <p>1. Чойжин ламын сүм музейн Гол сүмийн дээврийг сэргээн засварлах ажлыг гүйцэтгэж буй “Их очирт хүрдэн” ХХК-ийн хүний нөөц, ашиглаж буй тоног төхөөрөмж болон Гол сүмийн дээврийн зураг төсөлд тус тус хяналт дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>2. Архангай аймгийн Өлзийт суманд орших Өөлд бэйсийн хүрээний дуганы сэргээн засварлах ажил гүйцэтгэх гэрээнд хяналт дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлэв. Дурсгалт барилгыг сэргээн засварлах ажилд зөвлөмж өгч, арга зүйгээр хангасан нь мэргэжлийн бус сэргээн засварлалтаас үүдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.</p>	100%
5.2	Цагдаагийн ерөнхий газартай		Хамрагдсан объектын тоо	Анх удаа	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж	Музейн хяналтын камержилт, хамгаалалтын системийн мэдээллийг цуглуулах 16 үндсэн, 60 дэд асуулга бүхий	100%

	хамтран соёлын өвийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр объектод эрсдэлийн шинжилгээ хийх				байгаа 2 дээш объектын аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг нөлөөт хүчин зүйлс, эрсдэлийг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	судалгааны маягтыг музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургуулийн лаборатори зэрэг 43 байгууллагад хүргүүлсэнээс 33 нь мэдээгээ ирүүлсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд: - IP камер ашигладаг 18, - IP болон Аналог камер хосолсон 9, - Аналог камер ашигладаг 5 - Камерын системгүй 1 байгууллага тус тус байна. Энэхүү судалгаа нь соёлын өвийг хадгалагч байгууллагуудын аюулгүй байдлын камерын системийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний төлөвлөлтөд суурь мэдээлэл болно.	
5.3	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын хүрээнд					1. Нийслэлийн Засаг даргын А/1191 захирамжаар дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг боловсруулахад оролцсон. 2. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/345 тоот захирамжаар Улаанбаатар хот орчмын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалалтын бүс тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус тус ажилласан. 3. Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газар, Стандарт хэмжил зүйн газраас боловсруулж буй “Газарзүйн мэдээлэл, Түүх, соёл, археологийн өвийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт, стандарт”-ын төсөлд санал өгсөн.	100%
5.4	Хөвсгөл аймгийн нутгаас олдсон археологийн дурсгалыг Улаанбаатарт шилжүүлэн авчирсан ажил					Соёлын сайдын 2021 оны А/69 дугаар тушаал, Үндэсний төвийн захирал 2021 оны А/32 тоот тушаалаар байгуулагдсан хээрийн судалгааны баг Хөвсгөл аймгийн Түнэл сумын уугуул, Мөрөн сумын “Авьяс” дунд сургуулийн дүрслэх урлагийн багш Дэмбэрэлийн Нямтогтохын 2020 онд тус сумын нутаг Цагаан толгой хэмээх газраас	100%

						олж илрүүлсэн археологийн олдворуудыг Улаанбаатарт шилжүүлэн авчирсан. Эдгээр археологийн олдвор цутгуурын чулуун хэв, хоёр хүрэл тогоо, хүрэл ооль, хүрэл эдлэлүүдийн хагархай хэсгүүд нь манай улсын нутгаас анх удаа бүрэн бүтэн олдож байгаа бөгөөд төмөрлөг боловсруулалт, үйлдвэрлэлийн түүхийг тодруулахад шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой үнэ цэнтэй олдворууд юм.	
5.5	Цогтын цагаан байшингийн нуман хийцэд түр бэхэлгээ хийсэн ажил					Дурсгалт барилга дээр хэмжилтийн болон ажлын зураг боловсруулж, түр модон бэхэлгээ хийсэн. Сэргээн засварлах ажлын арга зүйг боловсруулах зорилгоор 20 цэгээс материалын дээж авсан. Мөн хадгалалт хамгаалалтын зорилгоор агаарын зураглал, гадаргын тоон загвар 3D модель үүсгэж мэдээллийн санд хадгалав. Хэрмэн ханын нуман хаалга болон бусад шаардлагатай газруудад түр модон бэхэлгээ хийснээр нурах эрсдэлийг бууруулав.	100%
5.6	Улаанбаатар дахь ТИКА-ийн төлөөлөгчийн газарт “Монгол-Туркийн хамтарсан Чулуун соёлын өв-Археологийн дурсгалыг хамгаалах, чадавхийг бэхжүүлэх, сэргээн засварлах хамтарсан лаборатори байгуулах” төсөл боловсруулж, хүргүүлсэн.					Монгол-Туркийн соёлын өвийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд чулуун дурсгалын хадгалалт хамгаалалтын судалгааны лаборатори байгуулахаар харилцан тохиролцсон. Лаборатори байгуулагдсанаар Монгол нутаг дахь чулуун дурсгалын хадгалалт, хамгаалалтын сэргээн засварлалтын чадавхи сайжирч, чулуун дурсгалын судалгааны цар хүрээ өргөжих боломж бүрдэнэ. Цаашид хамтын ажиллагааг Түрэгийн үеийн чулуун дурсгалуудын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, хамтарсан судалгааны бүтээл хэвлүүлэх, олон улсад сурталчлан таниулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэхээр төлөвлөж байна.	100%

5.7	Соёлын яамнаас өгсөн чиг үүргийн хүрээнд: “Амжилтын эзэд” контент бүтээх, соёлын брендингийн судалгаа хийх” ажил.					Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-ний 18 дугаар ажил, Соёлын сайдын А/80 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, “21 аймгийн ирээдүйн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, Амжилтын эзэд контент бүтээх, соёлын брендингийн судалгаа хийх” ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Сонгогдсон “Би Эм Эн Би” ХХК-тай 180 сая төгрөгийн төсөвт өртөгтэй уг ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан. Үүнд: - 21 аймаг, нийслэлийн авьяаслаг хүүхэд багачуудыг оролцуулсан “Амжилтын эзэд” соёлын өвийг өвлөн уламжлуулах контентийн 3 цаг 35 минутын митраж бүхий нэвтрүүлэг, -7-9 минутын митраж бүхий 21 аймаг, нийслэлийн видео контент, 21 аймгийн оролцогч хүүхдүүдийн фото зураг, дуу, дүрсний бүхий контентуудын (2ТВ, 0.5ТВ hard) цахим файл, -21 аймаг орон нутгийн соёлын өвийг сурталчлан таниулах “Ирээдүйн амжилтын эзэд” контент төслийн тайлан, - “Орон нутгийн соёлын бренд бүтээгдэхүүний судалгаа”-ны ажлын тайланг гэрээ ёсоор хүлээн авч, хувийг Соёлын яаманд хүргүүлсэн. Контентийг бүтээснээр соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч ирээдүйн залгамж халааг илрүүлэх, хөхиүлэн дэмжих, олон нийтэд таниулж сурталчилсан.	100%
5.8	Соёлын яамнаас өгсөн чиг үүргийн хүрээнд:					Соёлын сайдын 2021 оны А/68 тушаалыг хэрэгжүүлж дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:	100%

	Археологийн сан хөмрөгийг тохижуулах ажил.					<ul style="list-style-type: none"> - Археологийн хүрээлэнгээс нийтдээ 1470 хайрцаг археологийн олдвор, эд өлгийн зүйлийг Үндэсний төвийн барилгын сан хөмрөгт нүүлгэн шилжүүлэх ажлыг 2021 оны 6 дугаар сард зохион байгуулсан, - Археологийн олдворын сан хөмрөгийг тохижуулахад хөргүүрийн систем, цаасан, хайрцаг, хуванцар хайрцаг, даацын төмөр тавцан зэрэг тоног төхөөрөмж нийлүүлэх, угсрах ажлыг, чийгшил дулаан хэмжигч, төмөр шат зэрэг ажлын багаж хэрэгслийг зохих хуулийн дагуу нийлүүлэгч компаниудтай ажлын гэрээ байгуулан гүйцэтгэж, тайланг Соёлын яаманд хүргүүлсэн. <p>Үндэсний төвийн археологийн сан хөмрөг зориулалтын зарим нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан.</p>	
5.9	Соёлын яамнаас өгсөн чиг үүргийн хүрээнд: Баримтат өвийн үндэсний бүртгэлийн систем хөгжүүлэлтийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажил.					<p>Соёлын яамнаас өгсөн чиг үүргийн хүрээнд Баримтат өвийн үндэсний бүртгэлийн систем хөгжүүлэлтийн ерөнхий төлөвлөгөөг боловсрууллаа. Уг төлөвлөгөөнд:</p> <ul style="list-style-type: none"> - Цахим бүртгэлийн програм хангамжийн ерөнхий шаардлага, - Цахим санг ажиллуулахад шаардлагатай сервер тоног төхөөрөмжийн үзүүлэлтийг тус бүр тусгасан болно. <p>Энэхүү ерөнхий төлөвлөгөө нь цаашид баримтат өвийн цахим системийг үндэсний хэмжээнд хөгжүүлэх ажлын суурь зарчим болох ач холбогдолтой.</p>	100%

5.10	Соёлын яамнаас зохион байгуулсан Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд:						<p>1. “Дэл уулын чулуун судар” үзэсгэлэнг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, “Дэл уулын гайхамшиг” ТББ-тай хамтран 2021 оны 11 дүгээр сард зохион байгуулсан. Үзэсгэлэнд Дэл уулын хадны зургийн дардас, хуулбарууд, гэрэл зураг, компьютер график ашиглан 360° виртуал тур хэлбэрээр хийсэн баримтат кино зэргийг дэлгэн үзүүлж, хадны зургийн дүрслэлээс сэдэвлэн зохиомжил “Хөмөргөн гурвалжин” бүжгийг толилуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэл бэлэг дурсгалын зүйлсийн загварыг олон нийтэд танилцуулсан.</p> <p>2. “Соёлын өвийн үнэлгээ: асуудал, шийдэл, боломж” зөвлөлдөх уулзалтыг 2021 оны 11 дүгээр сарын 12-нд зохион байгуулсан. Соёлын өвийн үнэлгээ, эрх зүйн асуудлын хүрээнд илтгэл хэлэлцүүлж, соёлын өвийн үнэлгээний чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог өргөжүүлэн зохион байгуулах, хууль эрхзүйн зохицуулалтыг шинэчлэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх талаар санал, зөвлөмж гаргасан.</p> <p>3. “Сүм, хийдийн үнэт зүйл: хэрэглээ, хамгаалал, зохицол, хөгжил” хэлэлцүүлгийг Гандантэгчэнлин хийд, Дэлхийн өв-Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаатай хамтран 2021 оны 11 дүгээр сарын 13-нд зохион байгуулсан. Хэлэлцсэн сэдвээр оролцогчид санал солилцож, бурханы шашны байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр, боломж буйг тодорхойлон дүгнэж, зөвлөмж гаргасан.</p> <p>4. “Шинжлэх ухаан дахь музейн оролцоо” эрдэм шинжилгээний бага хуралд</p>	100%
------	---	--	--	--	--	--	--	------

					<p>“Шинжлэх ухаанд хэрэглэгдэж буй технологийг музейд ашиглах нь” сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн.</p> <p>5. “Хорин нэгэн Дара эхийн чуулган” үзэсгэлэнгийн дэглэлт болон үзмэрийн баглаа, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангахад хамтран ажиллав.</p> <p>Эдгээр арга хэмжээнүүд нь соёлын өвийн хууль эрхзүйн орчин, салбарын бодлого, шийдвэрийн хүртээмж, асуудлыг шийдвэрлэх гарц гаргалгааг тодорхойлон төлөвлөлт, шийдэлд хүрэхэд нэг алхам нэмэгдсэн онцлог арга хэмжээ болсон ба ажлын тайланг Соёлын яаманд хүргүүлсэн.</p>	
5.11	Эрдэм шинжилгээ судалгааны ажил:				<p>Эрдэм шинжилгээ чиглэлээр 5 судалгаа хийгдсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дендроархеологийн судалгаа; 2. Үл хөдлөх дурсгалын хүрээлэн буй орчны эрсдэлийн судалгаа; 3. Чойжин ламын сүм музейн төв замын хашлага хэсгийн хөрсөнд давсжилт тогтоох, хашлаганы гэмтлийн шалтгааныг тодорхойлох судалгаа, 4. Говьсүмбэр аймаг Боржигон-Өв музейн сан хөмрөгт 1 сарын турш харьцангуй чийгшил, дулааны хэмжилтийн харьцуулсан судалгаа, 5. ШУА-ийн Математик, тоон технологийн хүрээлэн, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаатай хамтран түүх соёлын үл хөдлөх дурсгалын хүрээлэн буй орчны судалгаа хийсэн. <p>Дээрх судалгаануудын үр дүнд соёлын биет өвийн материал судлал, хадгалалт хамгаалалтын тогтвортой орчин бүрдүүлэх суурь судалгааны мэдээллийн сан үүснэ.</p>	100%

5.12	Сургалтад илтгэл хэлэлцүүлсэн талаар:				<p>Эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр 7 илтгэл хэлэлцүүлэг, 4 өгүүлэл бичсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Усан доорх соёлын өвийг хамгаалах нь”, 2. Үл хөдлөх дурсгалын өнгө будгийн гандалт, гэмтлийн хэмжээг тогтоох судалгааны үр дүнгийн тайлан хэлэлцүүлэг, 3. “Цаасан суурьтай баримтат өвийн хадгалалт хамгаалалт” сэдэвт илтгэл, 4. “Уйгурын нийслэл Харбалгас хотын тууриас илэрсэн олдворуудад хийгдсэн материал судлал болон хадгалалт хамгаалалт хийгдсэн ажлын үр дүн” сэдэвт илтгэл, 5. Дурсгалт уран барилгын хадгалалт хамгаалалтын чиглэлээр илтгэл, 6. “Өндөр Гэгээний соёлын өв-2021” эрдэм шинжилгээний цахим хуралд “Өндөр гэгээнтэй холбогдох эд өлгийн зүйлс” илтгэл, 7. Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүссэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан зохион байгуулсан “Монголчуудын бичиг номын өв, соёл” эрдэм шинжилгээний хуралд “Соёлын баримтат өвийн төрөл зүйл” сэдэвтэй илтгэл тус тус хэлэлцүүлсэн. 8. “Музей судлал”, “Богд хааны ордон музейн тусгай сэтгүүл”-д өгүүлэл хэвлүүлсэн. <p>Эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлэг, өгүүлэл хэвлэгдсэнээр соёлын биет өвийн хүрээлэн буй орчны эрсдэлийн судалгаа, хадгалалт хамгаалалтын тогтвортой орчин бүрдүүлэхэд хувь нэмэр болох ба суурь судалгааны онолын мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн.</p>	100%
------	---------------------------------------	--	--	--	---	------

5.13	Соёлын өвийг 3D-ээр баримтжуулах ажлын хүрээнд:				Япон улсын Нарагийн соёлын өвийн хүрээлэнгийн судлаач Ямагучи Хирошито хамтран хэрэгжүүлж буй “Шороон бумбагарын бунхант булшны олдворын 3D баримтжуулалт” төслийн хүрээнд 3D модель үүсгэхэд зориулан гэрэл зураг авах тохируулгын ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэхүү аргачлалын дагуу Хархорум музейн сан хөмрөгт хадгалагдаж буй Шороон бумбагарын олдворуудын гэрэл зургийг 12 дугаар сард авч 2022 оны 6 дугаар сард олдворын 3D модель боловсруулж дуусгахаар төлөвлөж байна. Энэхүү ажлын гол ач холбогдол нь олон нийтийг археологийн дурсгалтай виртуаль орчинд танилцах боломж олгох, сонирхолтой хэлбэрээр сурталчлах явдал юм.	100%
5.14	Соёлын өвийн тоон дүн статистикийн мэдээний маягтыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах:				Үндэсний төвийн захирлын 2021 оны А/69 тоот тушаалаар Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн ажлын дотоод хэрэгцээнд түүх, соёлын үл хөдлөх дурсгал, хөдлөх дурсгалт зүйл, соёлын биет бус өв тус бүрээр тоон дүн мэдээг цуглуулах, нэгтгэх маягт, нөхөх заавар тус тус батлагдсан. Соёлын өвийн тоон дүн мэдээний маягт батлагдсантай холбогдуулан улсын 12 музей, аймаг, орон нутаг, нийслэлийн 24 музей, эрдэм шинжилгээний 3 хүрээлэн, Үндэсний номын сан, Эрдэнэсийн сан, 1 сүм хийд зэрэг 42 байгууллагын Бүртгэл, мэдээллийн санч, 21 аймаг, нийслэлийн соёл хариуцсан мэргэжилтэнүүд зэрэг нийт 63 хүнийг соёлын өвийн мэдээний маягтыг нөхөх тухай заавар арга зүйгээр хангасан. Мэдээний маягтуудыг Монгол Улсын “Статистикийн мэдээллийн маягт MN5522:2005” стандартыг баримтлан боловсруулсан нь соёлын өвийн тоон дүн статистикийн мэдээний маягт	100%

						боловсронгуй болж, хуульд заасан тогтолцооны дагуу бүртгэл, мэдээллийн сангуудаас тоон дүн мэдээг хүлээн авах, нэгтгэхэд ажилд ахиц дэвшил гарах нөхцөл бүрдэж байна.	
5.15	Он дамжиж хэрэгжиж буй ажлын хүрээнд:					“Ковид-19” цар тахлын улмаас хойшлогдсон байсан Соёлын сайдын 2020 оны А/23 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших Уйгурын нийслэл Харбалгасны дэргэд байрлах гэрэлт хөшөөний том, жижиг 6 хэсэг чулуун дурсгалыг Улаанбаатар хотод зөөж шилжүүлэх ажлыг 2021 оны 6 дугаар сард хийж гүйцэтгэв. Зөөж шилжүүлсэн дурсгалыг Үндэсний төвийн чулуун дурсгалын лабораторид байршуулсан ба ажлын тайланг Соёлын яамны Соёлын өвийн газарт хүргүүлсэн. Дурсгалыг зөөж шилжүүлснээр хадгалалт хамгаалалтын нөхцөл сайжирч, авран хамгаалагдав.	100%
<p>2021 онд нийт 43 арга хэмжээ хэрэгжүүлж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тайланд тусгагдсан 25, - Нэмэлтээр 14, - Он дамжиж хэрэгжсэн 1, - Хавсралт 1, 2 дугаарт тусгагдсан 6 (3 нь тайланд давхардсан) арга хэмжээ тус тус байна. <p>Тайлангийн гүйцэтгэл 97.81%-тай байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - 38 ажил 100% (тайланд тусгагдсан 21, нэмэлтээр 14, он дамжиж хэрэгжсэн 1, хавсралтад тусгагдсан 2), - 1 ажил 96% (тайланд тусгагдсан 1), - 2 ажил 80% (тайлан болон хавсралтад тусгагдсан 2), - 2 ажил 75% (тайланд тусгагдсан 2). 							

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хэрэгжилт болон тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт	420.0	Арга хэмжээний хэрэгжилт	Авсан гэрчилгээний хугацаа дууссан байна.	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад 6 ажилтанг хамруулсан байна.	Уг ажлын хэрэгжилт гүйцэтгэлийн тайлангийн 3.1-т тусгагдсан.	
2	Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт	300.0	Арга хэмжээний хэрэгжилт	Холбогдох ажилтнууд сургалтад хамрагдсаар ирсэн.	Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг анхан шатны мэдлэг олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.	Уг ажлын хэрэгжилт гүйцэтгэлийн тайлангийн 3.1-т тусгагдсан.	
3	Мэргэшүүлэх сургалт	Төсөв шаарда хгүй	“Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт”-ын чиглэлээр 4-өөс доошгүй удаагийн цахим сургалтад хамрагдсан байдал	Шинээр	Азийн өндөр хөгжил бүхий 2-оос доошгүй улстай (БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн г.м) хамтарсан цахим сургалтад мэргэжилтнүүдийг хамруулсан байна.	Уг ажлын хэрэгжилт гүйцэтгэлийн тайлангийн 4.3-т тусгагдсан.	

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хэрэгжилт болон тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	Цалин хөлс, ур чадварын нэмэгдэл, мөнгөн урамшуулал, шагнал олгох баталгаатай нөхцөлийг хангах	581,811.8	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2 дугаар хавсралт, 4 дүгээр хавсралтын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ур чадварын нэмэгдлийг, тухайн ажилтны ажлын бүтээмж, чанар, хүртээмж, үзүүлэлт, гүйцэтгэл, ачааллыг дүгнэж үр дүнгийн урамшууллыг дотоод журам, хөдөлмөрийн тухай хууль, төрийн албаны тухай хуульд	Салбарын шагналаар шагнуулах болзол хангасан 6 ажилтанг шагналд тодорхойлсон байна. Ажилчдын ур чадварын нэмэгдлийг холбогдох хууль журмын дагуу улирал бүр дүгнэн урамшуулна. Үндэсний төвийн ажилтан, албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж ажилчдад олгох үр дүнгийн урамшууллыг жилд 2 удаа олгох, Ажилтны бүтэн жилийн ажлын үзүүлэлт, үр дүнг үнэлж онцгой сайн ажилласан	Ажлын амжилт, бүтээлээрээ шалгарч төрийн болон салбарын шагналаар шагнуулах болзол хангасан 1 ажилтан “Алтан гадас” одонгоор, 3 ажилтан “Хөдөлмөрийн хүндэт” медалиар тус тус шагнагдсан. - Батлагдсан цалингийн санд уялдуулан 1-11 сард Үндэсний төвийн 35 ажилтан албан хаагчдын ажлын үр дүн, ур чадварын нэмэгдэлд 43,656.529 төгрөгийг, эхний хагас жилийн үр дүнгийн урамшуулалд 11,769.500 төгрөгийг тус тус олгосон.	100%

				нийцүүлэн олгож байна.	ажилтан, албан хаагчдад жилийн эцэст 1 удаа мөнгөн урамшуулал тус тус олгоно.		
2	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах	0.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Ажилчдын эрүүл мэндэд анхаарах асуудын хүрээнд бүх ажилчдыг уураг, бөөр, цусны шинжилгээний тестерээр; Дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс амны хаалт, гар ариутгах бодисоор байгууллагын боломжид нийцүүлсэн; Байгууллагын эмийн сангийн эмийн хангамжийг сайжруулан ажиллаж байна.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг шинэчлэн байгуулна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллах зөвлөгөөг байнга өгч тэмдэглэл хөтөлсөн байна. Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт 1 удаа хамруулах боломжоор хангасан байна. ХАБ-ын сургалтыг 2 удаа зохион байгуулна. Шинэ байранд үйл ажиллагаа явуулж эхэлсний дараа хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн байна.	“Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлах ажлын хүрээнд түгээмэл ашигладаг химийн бодисуудын ашиглалт, хадгалалтын горим, хөдөлмөрийн аюулгүй байдал” сэдвээр сэргээн засварлагчдыг хамруулан дотоододоо сургалт зохион байгуулав. - Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс 2021 онд 10 удаагийн худалдан авалтаар 806,070 төгрөгийн үнэ бүхий амны хаалт, гар ариутгагч бодис, мэдрэгчтэй гар ариутгагч халуун хэмжигч авч халдвар хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэн. - Шинэ байрны гэрчилгээ гараагүй байгаатай холбоотойгоор ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийгдэх ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдож байна.	80%
3	Ажлын таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх	0.0	Арга хэмжээний хэрэгжилтийн чанар	Ажилчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх хүрээнд албан хэрэгцээнд ашигладаг номын сангийн баяжилтыг	Ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах боломжийг бүрдүүлэх, Мэргэжил ур чадвараа дээшлүүлэх	- Докторын зэрэг хамгаалсан 1 ажилтанд “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу 1 сарын цалингүй чөлөө олгосон. - Магистрын сургалтад сурч буй 3 ажилтныг хичээлийн цагийн хуваарийнхан дагуу ажлаас чөлөөлж сурах нөхцөл боломжоор тус тус хангасан.	100%

				хийсэн. Албан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр ханган ажилласан.	боломжийг хангасан байна, Ажлын байрны орчинг сайжруулсан байна, Албан хэрэгцээнд ашигладаг номын сангийн баяжилтыг хийсэн байна.	- Үндэсний төв нь шинэ байранд нүүж орсноор 1 ажилтанд ноогдох ажлын байрны талбайн хэмжээ хүртээмжтэй болж ажлын байрны орчин нөхцөл эрс сайжирсан. - Соёлын яамнаас ажлын албан хэрэгцээнд 1,004.130 төгрөгийн үнэ бүхий 8 нэрийн 24 ширхэг ном өгсөн ба байгууллагын төсвөөс 399,600 төгрөгийн үнэ бүхий 7 нэрийн 16 ширхэг номыг худалдан авч байгууллагын номын санг 15 нэрийн 40 ширхэг номоор баяжилт хийсэн.	
	<ul style="list-style-type: none"> • Хавсралт 1-ын 3 арга хэмжээ тайлангийн 3.1; 4.3-т тусгагдсан. • Хавсралт 2-ын 3 арга хэмжээ: <ul style="list-style-type: none"> - Арга хэмжээ1- 100% - Арга хэмжээ2- 80% - Арга хэмжээ3- 100% тус тус гүйцэтгэлтэй байна. 						